

“АРДЫН ДҮРСЛЭЛИЙН ХЭЛ-7” буюу “САХАЛТАЙ ХОНЬ”

Д.Батжаргал

Түлхүүр үг: Ардын аман билиг, уран цэц, адилтгал, зүйрлэл, эерүүлэл, егөөдөл, дүрслэхүйн яруу хэрэглүүр.

“Ардын дүрслэлийн хэл” анхны өгүүлэл маань МУИС-ийн 70 жилийн ойн жил 2012 онд МУИС-ийн багш, эх хэл, соёлоо хайрлан хамгаалагч, их эрдэмтэн Чой. Лувсанжав багшийнхаа сургаал, захиасыг өчүүхэн ч атугай гүйцэлдүүлэх зорилгоор бичиж эхэлснээс хойш долоон жил өнгөрч өнөө жил долоо дахь цувралаа бичиж байна. Багш маань “Ардынхаа хэлний яруу сайхан дүрслэл, урын сангаас манай бичигч, сэтгүүлч, зохиолчид суралцахгүй байна. Суралцдагсан бол хичнээн сайхан уянгатай уншууртай “амттай” хэлээр ярьж, бичихсэн билээ. Монгол хэлээ сайжруулахын тулд эх хэлний хоёр ундаргаас ундаалах ёстой. Нэг дэх нь, бичгийн сурвалж. Улсын архивт байгаа шавь болон дөрвөн аймгийн сайхан найруулгатай бүтээлээс монгол бичгээр уншвал ямар ч сэтгэлтэй сэтгүүлч бичигч хүний хэл сайжирна. Нөгөө нь ардын хэл. Эгэл жирийн хүмүүс, эмгэд, өвгөдөөс хэчнээн сайхан үг гарч болно. Тэднээс бүтээлчээр суралцах ёстой” гээд олон жишээ дурдсанаас зөвхөн хоёрыг өгүүлье.

Б.Ринчен доктор Вандуй, Чой. Лувсанжав нарыг хамт 1964 онд Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр суманд шинжилгээний ангиар явж байжээ. Нэг айлд очоод гэрийн эзэнтэй хуучлаад сууж байтал гаднаас хажуу айлын эмгэн орж ирээд эзэгтэйгээс “Энэ буурал толгойтой хүн хэн бугай вэ” хэмээн асууж. Нэрийг нь хэлэнгүүт ханцуй дотроо залбиран **“Шүдлэн настай байхдаа алдар сайхан нэрийг нь сонсож байлаа. Шүдээ унасан хойно гэгээн дүрийг нь хардаг байжээ”** хэмээн хэлсэн гэдэг.

Өнөө бидний хэлээр бол залуу байхдаа нэрийг нь дуулж байлаа, хөгширсөн хойноо зүсий нь харлаа гэх молхи үгсийг шүлэг шиг сайхан яруу өгүүлж байна. Шүдлэн нас гэдэг мал аж ахуй эрхэлж ирсэн нүүдэлчдийн хэлэх үг. Гурван настай малд оноодог нэрийг хүншүүлэн өөртөө шингээн хэлэх нь ардын билиг хэллэг юм. Мөн Чой. Лувсанжав доктор нэгэн удаа нутагтаа очоод саахалт явсан айлынх нь хар хүн өнгөрснийг дуулаад халгаж халгаж гэрийн эзэгтэйтэй уулзахад **“Муу эгч нь уул шиг сайхан ханиа унагаад улаан цурав хэдэн нялх хүүхэдтэй үлдлээ. Дээр нь та нар байна, доор нь бид нар байна. Тэгээд болно биз дээ”** (Батжаргал Д. 2012) гэж хэлсэн байна. Энд эр нөхрөө уултай зүйрлэн хүндэтгэсэн, үр хүүхдээ өрөвдөлтэй балчир үлдсэнийг улаан цурав хэмээн тодотгосон, эрдэм боловсролтой хүмүүс дээр байгаа хойно болно оо гэсэн монгол эмэгтэй хүний уужуу сайхан сэтгэл цөм харагдаж байна.

Ийм жишээг бид малчин, ажилчин, багш, зохиолч, радиогийн сэтгүүлч, жолооч, дуучин, ардын авьяастан, өндөр настан, оюутан залуус зэрэг олон хүний яриагаар баяжуулж байна. Ардын аман билгийг тээж явдаг хүмүүс хаа ч тааралдах юм. 1960-аад оны үед одоогийн Завхан аймгийн Баянтэс сумын нутагт “Ганган” Маасаа гэдэг малчин эр байжээ. Ажил үйлс

сайтай нас намба тогтсон тэднийд аймаг сумаас төлөөлөгчид ажил амьдралтай нь танилцах үед гэргий нь тос хольж дайлжээ. Хайлмаг идэж байсан төлөөлөгчдийн нэг нь,

-Янжмаа гуай таны хольсон тосон дотор хялгас байна гэхэд Янжмаа:

-Саадаг нь сахлаг, саасан нь салан юм хойно, байлгүй яах вэ? гэж ярьсныг Завхан аймгийн Баянтэс сумын Н.Дэчин-Ишээс МУИС-ийн оюутан /2018 оны элсэгч/ Х.Цогт-Очир бидэнд бичиж ирүүлжээ. Мөн тэрээр Завхан аймгийн Баянхайрхан сумын Х.Болдбаатарын **“Уулын гөрөөс, усны жсараахай биш дээ. Сүүнд чинь хошуу дүрж, сүрэгт чинь уурга бариагүй”** гэж хэлдэг ардын сайхан үгийг илтгэх урлагийн хичээл дээр ярьсан юм. Монголчууд сүүнд ус холих, хүний юмаар хүүдэгнэх, бусдын мал зувчуулдаг зальтан, худлаа андуурдаг хулгайч зэргийг анддаггүй хүмүүс. Өнөөгийнх шиг хаа сайгүй дуран /камер/ байхгүй ч малч хүний ажиглалт нь хэний мал ямар зүстэй, хэн юу хийдгийг хар багаас нь ажигладаг болоод тэр. “Төр түмэн нүдтэй, төрсөн би хоёр нүдтэй” гэдэг үг ч эндээс гарсан байх. Нүүдэлчдийн ахуй амьдрал, ажил үйлс нь бүгд нүдэнд ил байдаг билээ.

Жараад оны үед нийслэлд зах зээл хөгжиж хотод ойрхон малчид сүү цагаан идээгээ авчирч худалдаалах нь чөлөөтэй байжээ. Энэ үед ардууд сүүгээ зарахын тулд,

Туулаар гараагүй

Гүүрээр гарсан юм

Шанага гэж худаг

Өнгө гэж будаг

Шанага нь тав

Шавхруу нь гурав гэж сурталчилдаг байв. Энэ нь нэгэн ёсны аман сурталчилгаа дэлхий дахины өргөн хэлээр “Реклам” байсан байна. Нөгөө талаар сүүндээ ус холиогүй гэдгээ уран үгээр батлан хэлж тунхаглажээ.

Нутаг нугадаа хэл ам нь гүйцэгддэггүй хүнийг цэцэн, шогч, егөөч хэмээн нэрийдэн хэлдэг уламжлалтай. Тэдний үгийг амнаас ам дамжуулан ярьсаар өнөөгийн үед авчирдаг. Харин энэ удаа академич Х.Сампилдэндэв агсан 1989 онд “Тоншуул” сонинд бичсэн “Цэцэн Маньбадарын домог” хуучаас сөхье. Тэрбээр цэцэн үгээрээ баяд ноёдыг давж байдаг шаггүй шогч, ардын билиг авьяастан нэгэн бөлгөө. Түүний тухай домог хууч элбэг ажээ. Айлд зарцлагдаж байсан Маньбадар хүүг өглөө хонио бэлчээхэд нь гэрийн эзэн:

-Цоогийн хадаар чоно ширүүн шүү. Тоо бүрэн, толгой бүтэн туугаад ирж үзээрэй гэжээ. Хонио хариулж байгаад бага үдийн хэрд хонь үргэхээр нь хашгираад хүртэл нэг хонины сүүлийг чоно тасдаж аваад зугтаж яваа нь харагдав. Хамаг хонио хаман хурааж хашгирч хөөсөөр хотлуулж ирвэл гэрийн эзэн:

-Ээ чааваас. Өглөө би чамд юу гэж хэллээ гэвэл Маньбадар:

-Тоо бүрэн толгой мэнд ирсэн. **Харин чүү гээд унаа явахгүй, туу гээд чоно үргэхгүй юм. Нэг төлөгний сүүл алдчихлаа. Уяж хоносон морь өлөн, ундгүй явсан би өлөн, ульж хоносон чоно өлөн, унтаад боссон ахайтан өлөн** байгаа биз дээ (Сампилдэндэв, 1989) гэжээ. Найруулгын тэгш хэмийн зарчим барьсан, толгой сүүл холбосон, шадлаад бичвэл бадаг шүлэг болохуйц эвтэйхэн болжээ.

Хараацай үүрээ зуун голын шавар түүж барьдаг гэдэг шиг анд нөхөд, бичгийн хүмүүс, зохиолчид, оюутан шавь нар, ах дүү, найз нөхөд ирүүлсээр ардын дүрслэлийн хэл маань зузаарсаар байна. Оюутан Ж.Наранмандах /МУИС-ийн ХШУИС-ийн 2018 оны элсэгч/ илтгэх урлагийн хичээл дээр хэд хэдэн сонирхолтой бичвэр ирүүлсэн юм. “Би сониуч зандаа хөтлөгдөн орой бүр ааваасаа янз бүрийн зүйл асууж шалгаадаг байлаа. Нэг өдөр, аав аа та цэргийн албанд ямархуу байсан бэ? гэж асуухад:

“Шинелийн дэгжинд татагдаж цэрэг болсон, шинэ даргын жигүүрт таахалзаж хал болсон, туулж барамгүй замыг шижигнүүлж явлаа, тунгалаг сайхан толийг гялалзуулж явлаа, тоолж барамгүй гурван жил байлаа, тонгорч чадаагүй нь захирагчийн охин

байлаа” гэж ярихад нь нүдээ бүлтийтэл гайхаж билээ” гэж бичсэн байна. Хөвөнтэй хөх дээл, бахиал гутлаар гангардаг хөдөө нутгийн хөвүүнд олон товч гялалзсан цэрэг шинель, хороом шиг өнгөлсөн гутал дэгжин харагдаж армид явах хүслийг нь өдөөсөн хийгээд ямархуу сүр жавхаатай цэрэг явснаа, хүсэл байвч, хүрч ойртож чадаагүй хэн нэгэн байсныг тун ч ойлгомжтой, бас бахархалтайгаар өгүүлжээ. Тэрбээр Увс аймгийн Тариалан сумын дунд сургуулийн 48 дахь төгсөлтийн найз Ц.Аюушжаргалынхаа хөгжилтэй түүхээс бас бидэнтэй хуваалцсан юм. Багаасаа бид хоёр зүү оромгүй сайхан найзууд байлаа. Зодоон цохионд нэгийгээ өмөөрөөд шууд дайраад орно. Нэг удаа сургуулийнхаа атмаантай гудамжинд ёстой л нэг улаан нүүрээрээ халз таарав. Зугтах ч эрхгүй, орилох ч аргагүй. Би найзаасаа арай л бие жижигхэн болохоор намайг атмаан янз бүрээр хэлж өдөж эхлэв. Яг энэ үед найз маань түүний урдаас зоригтойхон чанга дуугаар **“Манай сумын өндөр мод үндсээрээ унаж байна билээ. Магздай эгчийн хоёр ширхэг маахуур 500 болж өссөн байна билээ”** хэмээн өөртөө байсан 1000 төгрөгөө өгчихөв. Энэ нь хоёр утгаар тайлбарлаж болох зүйл юм. “Манай сумын өндөр мод унаж байна билээ” гэдэг нь “цаг цагаараа байдаггүй. Чи удахгүй ялагдах цаг болсон шүү” гэдэг утгаар “Магздай эгчийн хоёр ширхэг маахуур 500 болж өссөн” гэдэг нь “Бид хоёр хэзээ нэгэн цагт чамайг ялна” гэсэн далд санаатай үг байсан юм гэж Ж.Наранмандах бичсэн байна. Ямартай ч хөдөө сум, сургуулийн амьдралд болдог жирийн үйл явдал цаанаа ямар далд санаа ухаарал агуулдгийг ийнхүү сонирхолтой бичжээ.

Бас тэрээр, манай багш нэг удаа гитар сурцгаа гээд цоо шинэ сайхан эд өгөв. Бид чаддаггүй гэсэн ч зургаан утсыг нь ёстой л нэг балбаж гарав. Миний ээлж болоод яг тоглох гэж байтал Мягмарсайхан надаас гуйгаад авав. Анд нь чамд хөгжмийн гайхамшигийг үзүүлнэ. Би цагийн сайнд **“Гитарын утсыг тасартал тоглож, Гивааны хөшөөг (Увс аймгийн төв Улаангомд Улсын баатар Гиваанд зориулсан хөшөө Д.Б) амилтал дуулдаг байлаа”** гээд л цохиж гарсан даа гэж Увс аймгийн Тариалан сумын гуравдугаар багийн малчин Д.Баянмөнх хэлснийг дамжуулжээ.

Мөн тэрээр, хаваржаандаа буух гээд айлууд нааш цааш нүүдэллэж хөл хөдөлгөөнтэй байсан үе. Манай гэрийн урд талаар Баянаа ахын тэмээн ачаа явж өнгөрөв. Дэлхийн талыг эзэлсэн дээлтэй Монголынхоо ёсоо мартахгүйн тулд данхтай цай барин гүйв. Хэсэгтээ сонин хачин ярилцан сууж байтал, Баянаа ахын туслах малчин Тулга данх хоосон явуулахгүй хэмээн гар цайлгах юм асуутал Баянаа ах хариуд нь “Тулгаа минь дээ,

Сийлж зурсан Чингэстэй мөнгө ав

Сибирийн арлаас ирсэн чихэр ав гэснээ, ах чинь:

Түрийндээ хутгатай

Түрийвчиндээ мөнгөтэй

Май гээд өгчих баялагтай

Майхан босгоод баяжих ухаантай хүн шүү гэж бардам хэлж билээ хэмээн Ж.Наранмандах бичжээ. Энэ бол их сайхан хэллэг. Ялангуяа “Майхан босгоод баяжих ухаантай хүн шүү” гэдэг нь суусан газраасаа шороо атгаж босоод алт болгох чадалтай, зохиолч Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы “Итгэлт шиг овтой хүн” гэсэн санаа.

“Биетэй хүн биетэйгээ жишинэ. Үртэй хүн үртэйгээ жишинэ”. Хазгар доголон, харалган сохор хэнийг ч шоолж, доромжилж болохгүйг ухааруулжээ. Хэний ч үр хүүхэд ялгаагүй, ямар ч яваа билээ. Хэзээ ч тэднийг адалж, илүү харж, булуу долоож, доош нь хийж, “унтрааж” хэрхэвч таарахгүй гэсэн гүн утга бөлгөө. Энэ үгийг Хөвсгөл Алаг-Эрдэнэ сум. Нэгдүгээр баг дархад ястан, 63 настай Д.Энхтуяа 2019. 07. 19-нд Мөрөн суманд хэлсэн юм. Мөн тэрээр хотоос эхнэр хүүхэдтэйгээ амралтаар ирсэн дүүдээ **“Эгч нь хонь цөөтэй. Намар идэшний үеэр сахалтай хонь аваарай. Миний бэлэг болог”** хэмээн өгүүлэв. Ямаа хүйтэн хошуутай мал болохоор бэлэг сэлтэд ордоггүй, тиймээс эерүүлэн “сахалтай хонь” хэмээн өгүүлж байна. Ташрамд сонирхуулахад, Энэтхэгээс ирсэн бэлгийн бугуйвчинд 12 жилийн хонийг ямаагаар төлөөлүүлснийг сонирхон авсан юм. /Зургийг хавсралтад

нийтлэв/. Баянзүрх сумын уугуул Д.Энхтуяа нь өмнө хэд хэдэн сайхан үг хэлж байсан юм. Хээрийн замд явтал хэрээ гуаглахаар **“Зүс таань хар ч, зүрх таань цагаан билээ”** хэмээн тэнгэрийн жигүүртнийг аргадаж, хэдэн ач зээ нартаа ширүүлэхдээ **“Та нарын бор баас, шар шээсийг арилгаж, бойвыг чинь арчиж, борвийг чинь тэнийлгэж өсгөсөн билээ”** хэмээн зэмлэж байхыг нь сонссон билээ. Бас нэгэн айлын дүрххийн уурладаг түргэн зантай хүүхэд залуусын тухай **“Юм л бол ончрон тусаад явчих юм”** гэж хэлсэн нь тэмдэглэлийн дэвтэрт үлджээ. Хот айлын гадуур өнгөрч явтал сул дэл ноход машин, мотоцикл үрүү боргож гүйхээр **“Нохой даргаас айхгүй, нойр ноёноос айхгүй”**, наймаа арилжаа хийгээд, өгч авалцан тохиролцож салсаны дараа **“Малгайн жинс далд орохоор манайх болдог”** гээд ер нь үг үйлдлийн хариу хоосон буцаахгүй хүн болохыг ардын хэл сонирхон цуглуулж эхэлснийхээ дараа сая анзаарсан юм (Батжаргал Д. 2018:11). Ерөөс дархадууд бэлэн цэцэн үгтэй, шалмаг цочмог үйлд ончтой цэцэн хэллэгээрээ гайхалтай ард түмэн билээ. Саяхан ангийн анд Ж.Энхтайван багийн найзуудтайгаа хөзөр тоглож байхдаа **“Нарийндаа хатаж навчаар бааж байна”** (2019) хэмээн хошигнов. Талцсан тоглоомд өөрийнх нь талын этгээд том модоо /хөзрөө/ гамнаад байхаар нь ингэж хэлсэн юм. Өөрөөсөө харамлаж байж хожигдох вий, мах идэхгүй хоолоо их сойж байж тураалд орох вий гэсэн утгыг цөөхөн үгээр ончтой хэлж байна. Өнгөрсөн зун Монгол орны хаа сайгүй бороо хур элбэг, дэлгэр сайхан зун болсон. Энэ үеэр мөн сумын (Хөвсгөл аймгийн Баянзүрх сум) номын санч П.Нансалмаа **“Орой шидсэн уурга өглөө нь харагдахгүй тийм сайхан байна”** (2019) гэж нутгийн сонин дуулгав. Ногоо сайхан ургаж өгөөжтэй сайхан зун болж байгааг тун уран гоёмсогоор өгүүлж байна. Ер нь монголчууд “ногоо суга суга ургаж байна” гэж хэлдэг. Харин уурга далд орж байгааг өгүүлсэн жишээ тийм ч олон байдаггүй.

Ардын дүрслэлийн хэлний өмнөх цувралуудыг ажиглахад залуусыг сургаж сургамжилсан, залхуу хойргыг шогчлон “унтраасан”, өөдрөг тэнүүн явахыг захисан заасан үгс элбэг байх юм. **“Хайран хорин насаа хогт хаяж, хоёр төмбөгөрөө цогт булсан амьтан”** (Батжаргал Д. 2017:54), **“Залуу цагт эрдэм сураагүй байна гэдэг намар ургацгүй, насанд жаргалгүй амьдрахын нэр. Золбин үг, зэрлэг үйлдлийг эрдмийн мөр өөрчилнө”** (Батжаргал Д. 2017:54), **“Аавын ажилгүй охин хот айлын доог. Айлын ажилгүй эхнэр хорооны доог”** (Батжаргал Д. 2017:54) гэх мэтээр хэлсэн нь тун олонтоо.

Алс холын замд ардын дүрслэлийн үгс хэлэлцэх юутай сайхан. Бидний хэдэн зохиолч сэтгүүлчид Хөвсгөл аймгийн Рашаант суманд болсон МУСГЗ, нэрт зохиолч Д.Намсрай агсны мэндэлсний 70 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд оролцоод буцаж явсан үе. Радиогийн сэтгүүлч, МУСГЗ, яруу найрагч Б.Хүрэлбаатар “Миний аав Бямбажав **“Говийн туулайг салхи босгодог юм. Голын үгийг архи босгодог юм”** гэж хэлдэг байсан юм. Архи уусан үедээ талбиун сайхан байгаарай гэсэн санаа” (2019) хэмээн ярьсан юм. Монголчуудын хэлдэг “Цээжинд байгаа үгийг шилтэй цэнхэр хатгана” гэдэг үгийн өөр нэг хувилбар юм. Бас тэрээр “Тэрийн баянаас хээрийн баян. Гэнэт явахад дулаан хувцас”, “Түрүүлэх морь гараанаас эхэлж цойлдоггүй юм. Өмнө яваа морийг гүйцэж түрүүлэх сайхан байдаг юм. Амыг нь татаж цээжинд яваарай. Арын морьдын чимээг сонс” гэсэн сайхан үгсийг нэмэн зузаалсан юм. Яруу найрагч Л.Мягмарсүрэн Ардын уран зохиолч С.Дашдооровын **“Үрээ морь шиг үргэж яв, өөрийнхөө сүүдрээс дайжиж яв”** гэсэн үгийг залууст зориулан хэлдэг байсныг нэмэрлэлээ. Үнэхээр хүн өөрийгөө таньж сүүдрээсээ дайжиж чадвал амжилтад хүрэх алдаа оноогоо цэгнэхэд тус болох биз.

Төгсгөлд нь өгүүлэхэд, ардын дүрслэлийн хэл өмнөх цувралд орсон ярьсан үгс маань нийтийн хэрэглээнд орж байгаа баяртай мэдээг дуулгахад таатай байна. Манай тавдугаар цувралд орсон Хэвлэлийн хүрээлэнгийн дээд курсийн суралцагч Ц.Оюунгэрэлийн **“Аавтай хүний бардаж туулдаг хорвоог аавгүй хүн аргадаж туулдаг юм байна”** (Батжаргал Д. 2017:56) гэсэн үг маань нийгмийн сүлжээгээр олонд түгж байгаа нь олзуурхууштай байна. /зургийг оруулав/

Техник технологийн хөгжлийн эрин үед мэдээлэл хурдан шуурхай тархаж байгаа нь сайхан ч маазарсан, өөрсдийн ойлголцох зурвас мэндчилгээний хүрээнд хэт товчилсон, буруу бичин хошигносон үгсээ чөлөөтэй цацаж байгаа нь эх хэлний аюулгүй дархан байдалд ноцтой аюул заналхийлж байна. Охид хөвгүүд маань миний бичсэн хэдхэн үг монгол хэлэнд аюул занал учруулна гэж юу байх вэ. Юун сүртэй юм гэж хялбар бодож байж болно. Гэвч тийм биш, эх хэл эмзэг, эвдрэх эмтрэх нь хялбар аж. 2019 оны 6 дугаар сард **“Өчдөр нокорсон гарууд гарч бороонд гүйгээч ха ха”** гэж нэгэн залуу бичжээ. Энэ юу гэсэн үг вэ?. Би лав ойлгохгүй юм. Над шиг ойлгохгүй хүн хэчнээн байгаа бол. **“Ямар зовцорсон үгтэй, ядцарцан аятай, зудын клиптэй, сөнцөн хамтлаг вэ, ха ха”** гэх мэтээр бичиж байна. Энэ уг нь зөв бичсэн бол “Ямар зовсон үгтэй, ядарсан аятай, зудын клиптэй, сөнөсөн хамтлаг вэ?” гэж шоолж байгаа бололтой юм. Ингэж хүн хэлснээрээ бичээд байвал аялгуу сайхан монгол хэл маань юу болох вэ. Ийм бичлэг цахим ертөнцөөр дүүрэн. Бас хэл найруулгын илт алдаатай үгс ч элбэг байх юм. **“Маш сайн орос гэдэс цэвэрлэх цай ирлээ. Үнэ 10000”** гээд утсаа бичжээ. Үүнийг уншихаар монгол гэдсэнд төдий нөлөөгүй цай мэт буруу ташаа ойлголт төрүүлэх, ухаад бодсон хүнд ёстой дулимагхан муу найруулга харагдаж байна. Зүй нь, гэдэс цэвэрлэх маш сайн орос цай ирлээ гэвэл нийцэх мэт. Сүүлийн үед цахим ертөнцөд “Монгол эх хэлээрээ зөв сайхан бичигчгээ” гэсэн уриалга өрнөж байгаа нь юутай олзуурхуштай. Үүн дээр өвөг дээдсийнхээ ардын дүрслэлийн хэлээрээ ярьж бичдэг хэвшил тогтоон уран цэцэн харилцааны соёл дэлгэрүүлэе хэмээн нэмж уриалмаар байна.

ХУДОЖЕСТВЕННО-ВЫРАЗИТЕЛЬНЫЕ СРЕДСТВА-7”


ИЛИ “ОВЕЦ С УСАМИ”

Автор статьи рассматривает художественно-выразительные лексикой языка народов, приводя множество примеров, исследуя устные речи писателей, пастухов, студентов, рабочих, молодых и пожилых людей. Как и в предыдущих статьях, на этот раз автором отмечается, то что некоторые художественно-выразительные лексикой активно используется пользователями в социальных сети, таких как фейсбук. В конце статьи автором делается вывод о том что, активное внедрение этих лексик в журналистских текстах, в публицистике, литературных произведениях позитивно влияет на устной и письменной речах


Номзүй

- Батжаргал Д.** 2012. *Ардын дүрслэлийн хэл*. Сэтгүүл зүй. ЭШБ. №13 (380). МУИС. НШУС.
- Батжаргал Д.** 2017. *Ардын дүрслэлийн хэл-5 буюу “По” багийн үгийн эрчим*. ЭШ-ний хурлын эмхэтгэл. Уб.,
- Сампилдэндэв Х.** 1989 . *Цэцэн Маньбадарын домог*. Тоншуул сонин №14.
- Цэцэн билигт дархад. Эмх. Д.Батжаргал. 2018. Уб.,
- Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын уугуул, 60 настай Ж.Энхтайваны үг. 2019. 10. 26.
- Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын уугуул 54 настай П.Нансалмаагийн үг 2019. 7 дугаар сар
- Яруу найрагч Б.Хүрэлбаатарын яриа. 2019. 09. 17.

ХАВСРАЛТ



Зураг 1



Зураг 2